


БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Тэшиг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/79/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Булган аймаг 2022 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 7034-2580 Цахим хаяг: <a href="mailto:ankhbayard@audit.gov.mn">ankhbayard@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: <a href="mailto:enkhtsoodolj@audit.gov.mn">enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 7034-2495 Цахим хаяг: <a href="mailto:Tserenkhamg@audit.gov.mn">Tserenkhamg@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	12
3.1 Ерөнхий зүйл .....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БУА	Булган аймаг
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НА	Нийцлийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХГБХЗХ	Хүүхэд гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Ахуйн үйлдвэр, өргөн чөлөө 1-120,  
Жаргалант бөг. Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 86

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ТЭШИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.БАТСАЙХАН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэшиг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэшиг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:\bchighereg\2022A4\toot

22 25 01

006020144

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР

12 23 01 

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>18,253,672.63</b>	<b>21,998,722.63</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	10,714,702.63	10,964,522.63
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,004,946.00	3,051,748.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>8,709,756.63</b>	<b>7,912,774.63</b>
3351	Байгууллагаас авах авлага	840,764.00	43,782.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	7,868,992.63	7,868,992.63
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>7,538,970.00</b>	<b>11,034,200.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>7,538,970.00</b>	<b>11,034,200.00</b>
35410	Бичиг хэргийн материал	385,200.00	698,800.00
35420	Аж ахуйн материал	6,761,000.00	7,658,630.00
35470	Бусад хангамжийн материал	392,770.00	2,676,770.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,193,871,602.81</b>	<b>1,045,523,740.08</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,193,871,602.81</b>	<b>1,045,523,740.08</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,108,815,602.81</b>	<b>958,805,240.08</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,777,523,338.29	6,803,399,392.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	(6,334,028,134.58)	(6,373,709,568.61)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	232,457,000.00	232,457,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(151,013,090.88)	(172,540,010.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,238,156,582.76	1,281,404,582.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(722,753,317.75)	(927,061,579.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,438,624.00	54,414,624.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,898,732.37)	(12,546,033.67)
39214	Бусад үндсэн хөрөнгө	54,000,000.00	83,903,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,066,666.66)	(10,916,666.66)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>85,056,000.00</b>	<b>86,718,500.00</b>
39301	Програм хангамж	300,000.00	2,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(737,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	85,056,000.00	85,056,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,212,125,275.44</b>	<b>1,067,522,462.71</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>736,500,280.74</b>	<b>736,500,280.74</b>
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>736,500,280.74</b>	<b>736,500,280.74</b>
<b>422</b>	<b>Урт хугацаат зээл</b>	<b>736,500,280.74</b>	<b>736,500,280.74</b>
<b>4221</b>	<b>Төгрөг</b>	<b>736,500,280.74</b>	<b>736,500,280.74</b>
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	736,500,280.74	736,500,280.74
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>475,624,994.70</b>	<b>331,022,181.97</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>475,624,994.70</b>	<b>331,022,181.97</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	200,665,855.00	200,665,855.00
51101	Өмч: - төрийн	200,665,855.00	200,665,855.00

512	Хуримтлагдсан үр дүн	(739,722,619.96)	(884,325,432.69)
51210	Өмнөх үеийн үр дүн	(739,722,619.96)	(739,722,619.96)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(144,602,812.73)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,014,681,759.66	1,014,681,759.66
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,212,125,275.44</b>	<b>1,067,522,462.71</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>459,459,789.00</b>	<b>584,284,442.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>154,500.00</b>	<b>93,093,954.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	154,500.00	93,093,954.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	154,500.00	641,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	154,500.00	92,452,554.00
1200017	Үнэ төлбөргүй авсан бараа материал-ҮХ		92,079,554.00
1200018	Үнэ төлбөргүй авсан бараа материал-БМ		373,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>459,305,289.00</b>	<b>491,190,488.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	55,895,389.00	22,291,988.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	8,455,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,000,000.00	13,129,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,744,989.00	707,388.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,150,400.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	403,409,900.00	468,898,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	403,409,900.00	468,898,500.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>631,171,697.53</b>	<b>728,887,254.73</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>631,171,697.53</b>	<b>728,887,254.73</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	582,853,086.53	723,899,816.73
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	208,801,641.00	221,169,057.00
210101	Үндсэн цалин	165,914,805.00	175,644,557.00
210102	Нэмэгдэл	42,886,836.00	45,524,500.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,481,725.00	29,426,403.00
210201	Тэтгэврийн даатгал	18,766,630.00	20,721,239.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,208,000.00	2,212,100.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,766,100.00	1,769,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	442,400.00	442,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,298,595.00	4,280,963.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45,389,499.00</b>	<b>42,386,859.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,195,243.00	3,428,453.00
210302	Түлш, халаалт	36,786,840.00	36,791,993.00
210303	Цэвэр, бохир ус	4,407,416.00	2,166,413.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>50,071,474.00</b>	<b>42,150,029.00</b>
210401	Бичиг хэрэг	3,759,940.00	2,870,150.00
210402	Тээвэр, шатахуун	21,507,693.00	32,647,365.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,249,400.00	2,606,094.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	3,140,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,554,441.00	886,420.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>153,000.00</b>	<b>500,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	153,000.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,188,100.00</b>	<b>46,827,654.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	36,000.00
210602	Тавилга	-	438,000.00
210604	Урсгал засвар	6,188,100.00	46,353,654.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,642,304.00</b>	<b>3,094,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	3,600,000.00	-
210702	Дотоод албан томилолт	5,042,304.00	3,094,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,602,216.00</b>	<b>840,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,673,800.00	168,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	178,200.00	178,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	382,216.00	450,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>230,523,127.53</b>	<b>337,505,214.73</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,306,746.00	60,407,798.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	-	646,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	175,216,381.53	276,451,416.73
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>48,318,611.00</b>	<b>4,987,438.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>825,500.00</b>	<b>-</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	825,500.00	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,253,700.00</b>	<b>-</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,253,700.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>23,239,411.00</b>	<b>392,573.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,239,411.00	392,573.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	4,594,865.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,594,865.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(171,711,908.53)</b>	<b>(144,602,812.73)</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	1,110,112.87	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,110,112.87	-
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(1,110,112.87)</b>	<b>-</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(172,822,021.40)</b>	<b>(144,602,812.73)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	200,665,855.00	1,014,681,759.66	(739,722,619.96)	475,624,994.70
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	200,665,855.00	1,014,681,759.66	(739,722,619.96)	475,624,994.70
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	200,665,855.00	1,014,681,759.66	(739,722,619.96)	475,624,994.70
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(144,602,812.73)	(144,602,812.73)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	200,665,855.00	1,014,681,759.66	(884,325,432.69)	331,022,181.97

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>461,666,735.00</b>	<b>493,836,834.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>734,600.00</b>	<b>641,400.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	734,600.00	641,400.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	734,600.00	641,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	734,600.00	641,400.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>460,932,135.00</b>	<b>493,195,434.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	57,522,235.00	24,296,934.00

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	8,455,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,000,000.00	13,129,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,371,835.00	2,712,334.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,150,400.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>403,409,900.00</b>	<b>468,898,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	403,409,900.00	468,898,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>435,639,235.00</b>	<b>457,812,834.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>435,639,235.00</b>	<b>457,812,834.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>386,141,178.00</b>	<b>449,773,648.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>209,008,245.00</b>	<b>221,169,057.00</b>
210101	Үндсэн цалин	165,914,805.00	175,644,557.00
210102	Нэмэгдэл	43,093,440.00	45,524,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,481,725.00</b>	<b>29,426,403.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,766,630.00	20,721,239.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,208,000.00	2,212,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,766,100.00	1,769,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	442,400.00	442,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,298,595.00	4,280,963.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45,389,499.00</b>	<b>42,381,859.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,195,243.00	3,428,453.00
210302	Түлш, халаалт	36,786,840.00	36,786,993.00
210303	Цэвэр, бохир ус	4,407,416.00	2,166,413.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,863,600.00</b>	<b>25,767,344.00</b>
210401	Бичиг хэрэг	3,424,200.00	3,137,250.00
210402	Тээвэр, шатахуун	14,292,400.00	14,949,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,147,000.00	2,681,094.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	4,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,122,100.00</b>	<b>46,518,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	36,000.00
210602	Тавилга	-	438,000.00
210604	Урсгал засвар	6,122,100.00	46,044,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,642,304.00</b>	<b>3,094,000.00</b>

210701	Гадаад албан томилолт	3,600,000.00	-
210702	Дотоод албан томилолт	5,042,304.00	3,094,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,988,159.00</b>	<b>972,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,059,743.00	300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	178,200.00	178,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	382,216.00	450,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>62,145,546.00</b>	<b>79,944,385.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,945,546.00	79,294,385.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	650,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>49,498,057.00</b>	<b>8,039,186.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,253,700.00</b>	<b>-</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,253,700.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>23,239,411.00</b>	<b>3,444,321.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,239,411.00	3,444,321.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,004,946.00</b>	<b>4,594,865.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,004,946.00	4,594,865.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>26,027,500.00</b>	<b>36,024,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>25,873,000.00</b>	<b>36,024,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>25,873,000.00</b>	<b>36,024,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>25,873,000.00</b>	<b>36,024,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	-	22,748,000.00
223001	Бусад хөрөнгө	25,873,000.00	13,276,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(25,873,000.00)</b>	<b>(36,024,000.00)</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	469,478,500.00	469,539,900.00	(61,400.00)	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	469,478,500.00	433,515,900.00	35,962,600.00	92.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	469,478,500.00	428,528,462.00	40,950,038.00	91.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,212,100.00	221,169,057.00	43,043.00	100.0

210101	Үндсэн цалин	175,687,600.00	175,644,557.00	43,043.00	100.0
210102	Нэмэгдэл	45,524,500.00	45,524,500.00		100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,863,500.00	29,426,403.00	437,097.00	98.5
210201	Тэтгэврийн даатгал	21,015,000.00	20,721,239.65	293,760.35	98.6
210202	Тэтгэмжийн даатгал	2,212,100.00	2,212,100.00		100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,769,700.00	1,769,700.00		100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	442,400.00	442,400.00		100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,424,300.00	4,280,963.35	143,336.65	96.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,008,500.00	42,381,859.00	1,626,641.00	96.3
210301	Гэрэл, цахилгаан	4,013,800.00	3,428,453.00	585,347.00	85.4
210302	Түлш, халаалт	36,794,700.00	36,786,993.00	7,707.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	3,200,000.00	2,166,413.00	1,033,587.00	67.7
2104	Хангамж, бараа материалын зардал	25,785,200.00	25,767,344.00	17,856.00	99.9
210401	Бичиг хэрэг	3,141,200.00	3,137,250.00	3,950.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	14,949,000.00	14,949,000.00		100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,695,000.00	2,681,094.00	13,906.00	99.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,000,000.00	4,000,000.00		100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00		100.0
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00		100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00		100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,444,000.00	46,518,000.00	33,926,000.00	57.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,785,000.00	36,000.00	22,749,000.00	0.2
210602	Тавилга	11,615,000.00	438,000.00	11,177,000.00	3.8
210604	Урсгал засвар	46,044,000.00	46,044,000.00		100.0
2107	Томилолт, зочны зардал	5,842,600.00	3,094,000.00	2,748,600.00	53.0
210702	Дотоод албан томилолт	5,842,600.00	3,094,000.00	2,748,600.00	53.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,772,600.00	672,600.00	2,100,000.00	24.3
210803	Даатгалын үйлчилгээ	178,600.00	178,600.00		100.0

210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	450,000.00		100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00		100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00		2,100,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,050,000.00	58,999,199.00	50,801.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,400,000.00	58,349,199.00	50,801.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	650,000.00	650,000.00		100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		4,987,438.00	(4,987,438.00)	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		392,573.00	(392,573.00)	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		392,573.00	(392,573.00)	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох		4,594,865.00	(4,594,865.00)	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,594,865.00	(4,594,865.00)	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		36,024,000.00	(36,024,000.00)	
	Дотоод эх үүсвэрээр		36,024,000.00	(36,024,000.00)	
222001	Тоног төхөөрөмж		22,748,000.00	(22,748,000.00)	
223001	Бусад хөрөнгө		13,276,000.00	(13,276,000.00)	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	470,058,500.00	469,539,900.00	518,600.00	99.9
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	469,428,500.00	468,898,500.00	530,000.00	99.9
132001	Орон нутгийн төсвөөс	469,428,500.00	468,898,500.00	530,000.00	99.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	630,000.00	641,400.00	(11,400.00)	101.8
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0			
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17	17	-	
6	Удирдах ажилтан	3	3	-	
7	Гүйцэтгэх ажилтан	12	12	-	
8	Үйлчлэх ажилтан	2	2	-	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		24,296,934.00	(24,296,934.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		24,296,934.00	(24,296,934.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		21,245,186.00	(21,245,186.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		300,000.00	(300,000.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		300,000.00	(300,000.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		20,945,186.00	(20,945,186.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		20,945,186.00	(20,945,186.00)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,051,748.00	(3,051,748.00)
2132	Бусад урсгал шилжүүлэг			
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,051,748.00	(3,051,748.00)
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		24,296,934.00	(24,296,934.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		24,296,934.00	(24,296,934.00)
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		8,455,000.00	(8,455,000.00)
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		13,129,600.00	(13,129,600.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,712,334.00	(2,712,334.00)
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тэшиг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн толилуулга, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэшиг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/49 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хэтийн хөгжлийг орон нутгийн нөөц боломж, онцлог, улс аймгийн бодлого, чиглэлтэй уялдуулан боловсруулж, сумын ИТХ болон түүний Тэргүүлэгчид, төрийн гүйцэтгэх захиргааны байгууллага болох сумын Засаг даргыг бүрэн боловсрогдсон бодлогын зөвлөгөө дэмжлэгээр хангаж, тэдний үйл ажиллагааг явуулахад шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу тайлант онд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажиллаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэшиг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 631,171.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,311.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,418.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тэшиг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	10,714.7	10,964.5	249.8
Бараа материал	7,538.9	11,034.2	3,495.3
Үндсэн хөрөнгө	1,193,871.6	1,045,523.7	(148,347.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,212,125.2</b>	<b>1,067,522.4</b>	<b>144,602.8</b>
Урт хугацаат өр төлбөр	736,500.3	736,500.3	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	475,624.9	331,022.4	144,602.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,212,125.2</b>	<b>1,067,522.4</b>	<b>144,602.8</b>

Тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс 468,898.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 24,296.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 641.4 мянган төгрөгийг бүрдүүлэн нийт 493,836.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 488,849.4 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулан, 4,987.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Авлага тайлант хугацаанд 10,964.5 мянган төгрөг болж, 249.8 мянган төгрөгөөр өссөн нь 2003 оноос эзэн холбогдогч нь тодорхойгүй болж олон жил он дамжсан 7,868.9 мянган төгрөг, татаас санхүүжилтээс шалтгаалж үндсэн дансанд авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 11,034.2 мянган төгрөг болж 3,495.2 мянган төгрөгөөр өссөн нь бичгийн цаас, бичиг хэргийн материал, ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгалын буу, ариутгалын бодис, спирт, хөдөлмөр хамгаалалын хүрээнд галын буланг бүрдүүлэх материал, цэвэрлэгээний материал нөөцөлснөөс нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд сумын онцгой комисст ковид-19 холбоотой иргэдээс өгсөн хандиваар хамгаалалтын хувцас, ариутгалын бодис, Эрүүл мэндийн төвд түргэвчилсэн оношлуур, хамгаалалтын хувцас, ковид-19 эмчилгээнд тариа, хүчилтөрөгчийн баллон, багаж, хүн амын ундны усны худагны цахилгааны төлбөр, ковид-19 цар тахлын үед хяналтын цэгийн хүнс, ариутгал, шатахуун, сонгуулийн үйл ажиллагааны хүрээнд үлдсэн аж ахуйн шинжтэй материалыг шилжүүлэн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,045,523.7 мянган төгрөг болж 148,347.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгөөр тавилга, программ хангамж, вэб сайт, тоног төхөөрөмж, Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй ОНӨХХК-иас худаг, хашаа, байгаль хамгаалах сангийн эх үүсвэрээс хийгдсэн хөрөнгө оруулалтаар ухаалаг худаг, хогын сав, дрона зэргийг балансаас балансад шилжүүлэн авч, тайлант оны элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

Өглөг дансны үлдэгдэл 736,500.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь 2015 онд баригдсан уурын зуухны шинэчлэл, цэвэрлэх байгууламжийн өртгийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр эргэн төлөгдөж нөхцөлтэй зээлийг өглөгийг 2019 онд урт хугацаат өр төлбөрөөр бүртгэлд тусгаж, тайлагнаж эхэлсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бичилт хийгдээгүй, тайлант оны хуримтлагдсан үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээнд өөрчлөлт ороогүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 514,725.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 44,667.3 мянган төгрөгөөр бууруулж 470,058.5 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор төсвийн захирагчийн төсөвт өөрчлөлт ороогүй байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн 6 чиглэлийн арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 469,428.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 630.0 мянган төгрөгийн нийт 470,058.5 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 468,898.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 641.4 мянган төгрөгийн өөрийн орлогыг хэвлэх, хувилах үйл ажиллагааг иргэдэд үзүүлсэн орлогоос бүрдүүлэн, урсгал үйл ажиллагаанд 464,552.5 мянган төгрөгийг зарцуулж, 4,346.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 464,552.5 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 43.0 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 437.1 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар, байр ашиглалттай холбоотой зардал 1,626.6 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 33,926.0 мянган төгрөгөөр буюу 42.2 хувиар, хангамж, бараа материалын зардал 17.8 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар, томилолт зочины зардал 2,748.6 мянган төгрөгөөр буюу 75.4 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн, ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 2,100.0 мянган төгрөгөөр буюу 75.7 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 58.8 мянган төгрөг буюу 0.1 хувиар тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орлого дараах эх үүсвэрээс бүрдсэн байна. Үүнд:

- Өмнөх оны жилийн эцсийн авлага 2,004.9 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогоос,
- Ковид-19 цар тахалтай холбоотойгоор урьдчилан сэргийлэх зардалд 5,000.0 мянга, цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж төслийг санхүүжүүлэхээр 5,000.0 мянга, ойн хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх морин эргүүлийн урамшуулалд 2,329.5 мянга нийт 12,329.5 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс,
- Нэр бүхий байгууллага, иргэдээс нийт 8,455.0 мянган төгрөгийн хандив,
- Хамтарсан багийн сургалтын зардалд 300.0 мянган төгрөгийг аймгийн ИТХ-аас,
- Хагас жилийн мал тооллогын зардалд 657,3 мянган төгрөг, мэдээлэл цуглуулах судалгааны зардал 50.0 мянган төгрөгийг нийт 707.3 мянган төгрөгийг Статистикийн хэлтсээс,
- Нэр бүхий 10 өрхийн хүнсний дэмжлэгт 500.0 мянган төгрөгийг, ХГБХЗХөгжлийн газраас тус тус санхүүжсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилагдсан хөрөнгө 2,712.3 мянга, ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 13,129.6 мянга, төрийн болон төрийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 8,455.0 мянга нийт 24,296.9 мянган төгрөгийн орлого хүлээн авч, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаар 300.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаар 20,945.2 мянган төгрөг нийт 21,245.2 мянган төгрөгийг зарцуулан, 3,051.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Үндсэн хөрөнгийн 39201, 39203, 39205, 39207, 39301 дансанд 59 нэр төрлийн 6,303,649.6 мянган төгрөгийн хөрөнгө эзэмшилдээ байгаа элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна. Үлдэх өртөг тэг үлдэгдэлтэй ашиглалтын хугацаа бүрэн дууссан хөрөнгөнд нэмж элэгдлийн зардал байгуулагдахгүйгээс тухай тайлант хугацааны элэгдлийн зардал үнэн зөв илэрхийлэгдэхгүй дутуу тайлагнагдаж байна.

Нэмэлт санхүүжилтийн данс болон үндсэн үйл ажиллагааны зориулалтаас бусад арга хэмжээний зардлыг зарцуулахдаа зардлын эдийн засгийн ангиллаар зарцуулахаар зарцуулалтын эрх олгоогүйгээс шалтгаалж, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнтэй зөрүүтэй илэрхийлэгдэж байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 128 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба сар бүр 96 мэдээлэл, улирал бүр 4 мэдээлэл оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

↓ Шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,

↓ Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,

↓ Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналт хангалтгүй нь дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалттай нийцээгүй,

↓ Аудитаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүн болох 174,394.4 мянган төгрөгөөс 10 хувь буюу 17,439.4 мянган төгрөгийн хэмнэлт гаргахаар төлөвлөж тооцоогүй нь МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасан шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөнийг Тэшиг сумын Засаг даргын тамгын газрын 2021.06.10-ны өдөр 03/277 дугаар албан тоотоор хариу ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өөрийн эзэмшилдээ байгаа боловч хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн ашиглалтын хугацаа дууссан ч ашиглагдаж байгаа хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн шинэчлэн тогтоох, нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулалтын эрх нээхдээ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 305,906.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 13,716.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 289,631.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн үр дүнгийн тайланд 13,389.1 мянган төгрөгийн, Бараа материалын тодруулга тайланд 327.4 мянган төгрөг нийт 13,716.5 мянган төгрөгийн алдааг тусгаж баталгаажуулав.

Энэ нь УСНББОУС 27-д "санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", "Үнэн зөв толилуулга" нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг", НББОУС 8-ын 10.Б.1-д "аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, санхүүгийн гүйцэтгэл ба мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлэх" заалтуудтай нийцэхгүй, "эрх ба үүрэг", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 4.3 Албан шаардлага

4.3.1 Тавилга, багаж техникийн худалдан авах зардлаас 8 нэр төрлийн 26,976.0 мянган төгрөгийн ширээ сандал, кресль сэйф шкап зэрэг конторын тавилга бэлтгэсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэхь заалтыг хэрэгжүүлээгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаад Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин тавилга эд хогшил бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоож, "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

4.3.2 Цалингийн зардлаас таван сая төгрөгөөр дээш үнийн дүнтэй орлогын 15,661.1 мянган төгрөгийн гүйлгээний 3 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын 12 гүйлгээг 5 сая төгрөг хүрээгүй гүйлгээг нэмж өссөн дүнгээр 246,994.1 мянган төгрөгийг илүү мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"-д заасныг тус тус хэрэгжүүлээгүйд шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах, шилэн дансанд хугацаанд нь мэдээллийг иж бүрэн байршуулж, гарсан зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. **Бараа материал данстай холбоотой асуудал**

###### 1.1. Илрүүлэлт:

Бичиг хэргийн материалын дансанд ном, бусад хангамжийн материал дансанд хөрөнгийн шинж чанартай майхан, ном зэрэг 2,558.8 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь УСНББОУС 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт болон "ангилал" батламж мэдэгдлийг хэрэгжүүлээгүй байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

УСНББОУС 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох

бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

## 2. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

### 2.1. Илрүүлэлт:

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүн болох 174,394.4 мянган төгрөгөөс 10 хувь буюу 17,439.4 мянган төгрөгийн хэмнэлт гаргахаар төлөвлөж тооцоогүй байна.

### 2.2. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол болон МУЗГ-аас баталсан төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа шийдвэрүүдийг мөрдөж ажиллах.

## 3. Дотоод хяналттай холбоотой асуудал

### 3.1. Илрүүлэлт:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" гэж заасны дагуу 2020-2021 хичээлийн жилд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажиллаагүй байна.

### 3.2. Өгсөн зөвлөмж:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж, дотоод хяналт шалгалтын баг томилуулан ажиллуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Тэшиг сумын ЗДТГ	7	305,906.4	2	13,716.5	0	0	2	289,631.1	3	2,558.8